



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/75

Бөхт

Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-9.8 дахь хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн А/125 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын А/366 дугаар тушаалыг тус тус үндэслэн захирамжлах нь:


1. 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн 25 хоногийн хугацаанд Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын тов мэдээг малчид, мал бүхий иргэдэд хүргэн, бэлэн байдлыг хангуулж, мэдрэмтгий малыг бүрэн хамруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Б.Мядагмаа	(Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч)
Гишүүдэд	Э.Сумъяа	(1 дүгээр багийн Засаг дарга)
	Д.Шинэбаяр	(2 дугаар багийн Засаг дарга)
	Б.Цэрэнням	(Бөхт таван эрдэнэ ХХК-ны малын их эмч)

2. Вакцины дархлаа бүрэн тогтох хүртэл малын шилжилт хөдөлгөөн, отор нүүдлийг 21 хоногийн хугацаанд хориглосугай.

3. Дархлаажуулалтын ажлыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж шуурхай үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг (Б.Мядагмаа)-д тарилгын ажлыг үр дүнтэйгээр зохион байгуулж ажиллахыг Бөхт таван эрдэнэ ХХК (Б.Цэрэнням)-д, шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад үхэр сүргийг бүрэн хамруулах, малчид, мал бүхий иргэдэд тов мэдээг хүргэн бэлэн байдлыг хангуулахыг багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ